

Төсөл

ХУУЛЬ САХИУЛАХ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГА ХООРОНДЫН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллагууд мэдээлэл солилцож, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөлийн мэдээлэл ханган нэгтгэн боловсруулах, хүчирхийллийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ зөвлөмж гаргах, түүний хэрэгжилтийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллагын мэдээлэл солилцох журам нь Монгол Улсын Үндсэн хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай авах эрхийн тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжуудыг бусад актаас бүрдэнэ.

1.3. Гэр бүлийн хүчирхийллийн талаархи энэ зүйлд заасан мэдээллийг нэгдсэн мэдээллийн сангаар боловсруулах, хүчирхийллийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийх, зөвлөмж гаргах зэрэг ажлыг хангах ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөл хэрэгжүүлнэ.

1.4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд үүрэг хүлээсэн төлөөлөгчид байгууллага, албан тушаалтан нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөлд хүргүүлэх мэдээ, тайланг тогтоосон маягтын дагуу дараах хугацаанд илгээж болон бичгээр хүргүүлнэ. Үүнд:

- 1.4.1. Сарын мэдээг дараа сарын 10-ны дотор;
- 1.4.2. Улирлын мэдээг улирал бүрийн дараа сарын 10-ны дотор;
- 1.4.3. Хагас жилийн мэдээг хагас жилийн дараа сарын 10-ны дотор;
- 1.4.4. Жилийн мэдээг дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор;

1.5. Энэ журмын 1.4-т заасан мэдээний маягтын загварыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөл батална.

1.6. Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллагын дахь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуульд тогтоомжид заасан мэдээллийн сангаар мэдээллийг солилцох, ашиглахад Монгол Улсын Засгийн газрын 212 тоот тогтоомж батлагдсан “Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг ашиглах журам”, Хууль тогтоомжуудын дотоод хэргийн Сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Улсын ерөнхий прокурорын 2017 оны дугаар хамтарсан тушаалаар баталсан “Шүүх, хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ашиглах, түүний нууцлалыг хангах журам”-ыг тус тус баримтална.

Хоёр. Мэдээлэл солилцох, тайлагнах хүрээ

2.1. Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллагын нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргийн дагуу эзний журамд заасан мэдээллийг харилцан солилцож, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тайлагнана.

2.2.Хамтарсан баг үйл ажиллагааны мэдээг улирал тутам, дор дурдсан төв байгууллага, албан тушаалтан болон хамтарсан баг хуульд заасан үүргийн хүрээнд хийсэн ажлын тайланг хагас, бүтэн жилээр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохицуулах салбар зөвлөлд хүргүүлнэ. Үүнд:

2.2.1.хамтарсан багийн мэдээ, тайланд дараах агуулгыг тусгасан байна:

а)гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан талаар;

б)хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэл хүчирхийллийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлсэн ажил талаар;

в)нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн хохирогчид үзүүлэх үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлсэн ажлын талаар;

г)хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулсан ажлын талаар.

2.2.2.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тайланд дараах агуулгыг тусгасан байна:

а)харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаархи хөтөлбөрийн хэрэгжилтэд хариу тавьж ажилласан талаар;

б)гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар Засаг даргын тааламжтай мэдээллийг хэлэлцэж чиглэл өгсөн талаар;

в)сум, хороонд хамтарсан баг байгуулах, үйл ажиллагаанд нь хамрагдах тавьж ажилласан талаар.

2.2.3.бүх шатны Засаг даргын тайланд дараах агуулга тусгагдсан байна:

а)харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажил хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар;

б)хүчирхийллийн шалтгаан, нөхцлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн ажлын талаар;

в)иргэдийн хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан талаар;

г)хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэрт зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөл бүрдүүлсэн талаар.

2.3.Дараах төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн салбар хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар Зөвлөл болон прокурор байгууллага ажлын тайланг хагас, бүтэн жилээр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохицуулах Зөвлөлд хүргүүлнэ.

2.3.1.Хууль зүй, дотоод хэргийн яамны тайланд дараах агуулгыг тусгасан байна:

а)гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах хууль болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үүргийн хүрээнд зохион байгуулсан талаар;

б)олон нийтэд зориулсан сургалт, мэдээлэл, сурталчилгааны а зохион байгуулсан талаар.

2.3.2.Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тайланд түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, сэтгэл зүйн зөвл нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, хо зуучлах ажлыг зохион байгуулсан талаар тусгасан байна.

2.3.3.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулл тайланд дараах агуулгыг тусгасан байна:

а)боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур бай хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилтэнд хэ тавьж ажилласан тухай;

б)гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүү илрүүлэх, үйлчилгээ, туслалцаа, дэмжлэг үзүүлэх ур чадварыг эзэмш талаар хийсэн ажлын тухай.

2.3.4.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулл тайланд дараах агуулгыг тусгасан байна:

а)хохирогчид үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий эмнэлэгт ажилла цэгийн үйлчилгээний төвийг удирдлага, зохион байгуулалтаар хан ажлын талаар;

б)нийгмийн эрүүл мэндэд гэр бүлийн хүчирхийллийн үзүүлж б нөлөө, осол, гэмтэл, өвчлөлийн шалтгааныг судлах, мэдээллийн бүрдүүлж, холбогдох мэдээ, судалгааг мэдээллийн санд хүргэсэн талаар

в)гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүнийг илрү яаралтай болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмнэ мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, давтан сурга зохион байгуулсан ажлын талаар.

2.3.5.Соёл, урлагийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулл тайланд дараах агуулгыг тусгасан байна:

а)хүний эрх, эрх чөлөө, эрх тэгш байдлыг хүндэтгэсэн, гэр бү тэнцвэрт харилцааг дэмжсэн эерэг зан үйл, хандлагыг ний төлөвшүүлэхэд чиглэсэн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт т сурталчлах ажлыг зохион байгуулсан талаар;

б)хүчирхийллийг илэрхийлж, сурталчилсан агуулга бүхий урлагийн арга хэмжээ, аливаа уран бүтээл, утга зохиолыг нийтэд түгэ урьдчилан сэргийлэх, хяналт тавих, хязгаарлалт тогтоож ажилласан тал

2.3.6.Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тайланд асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээнд холбон зуу хэрэгжилтэнд хяналт тавих ажлын талаар тусгасан байна.

2.3.7.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар Зөвлө тайланд дараах агуулгыг тусгасан байна:

а)хохирогчид энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлэх үүрэг хүл ажилтныг давтан сургасан, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулж, мэрг арга зүйн удирдлагаар хангасан ажлын талаар;

б)хамтарсан багийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдл хангасан, туслалцаа дэмжлэг үзүүлсэн ажлын талаар;

в)энэ журмын 2.2.2-2.2.3-д зааснаар хүлээн авсан мэдээ, тайлан нэгдсэн танилцуулга;

2.3.8.Прокурорын байгууллагын мэдээ, тайланд гэр бүлийн хүчирхийлэл улмаас хүний амь нас хохирсон тохиолдол бүрийг нарийвчлан судалж дүгнэж гаргах, үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар холбоотой байгууллага, албан тушаалтанд мэдэгдэл хүргүүлж, хяналт тавьж ажиллагаа талаар тусгана.

2.3.9.Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагууд олон нийтэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаархи мэдээлэл түгээх, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулсан бусад хохирогчийг түр хамгаалах байраар хангасан болон хуульд заасан бусад үйлчилгээ үзүүлсэн ажлын талаарх тайлангаа хүргүүлж хамтран ажиллана.

2.4.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөл жилийн ажлын тайланг Засгийн газарт дараах агуулгыг тусган хүргүүлнэ. Үүнд:

2.4.1.Энэ журмын 2.3.1-2.3.9-д заасан ажлын нэгдсэн танилцуулга;

2.4.2.Салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулсан, чөлөөт өгсөн талаарх ажлын талаар;

2.4.3.Хүчирхийллийн шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийсэн, зөвлөх гаргасан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан ажлын талаар;

2.5.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангасан талаарх ажлын тайланг жил бүр Улсын их хуралд танилцуулахаар Засгийн газарт хүргүүлнэ.

2.6.Энэхүү журмын 2 дугаар зүйлд заасан мэдээллийн талаар Засгийн газарт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөл нь шүүх эрх мэдлийн, хууль сахиулах чиг үүрэг хэрэгжүүлэх болон бусад байгууллагуудын тухайн мэдээлэлд хамрагдах нэмэлт лавлагаа, тооцоо, аргачлал, тайлбар, тодруулгыг харилцан гаргуулавч авч болно.

2.7.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар Улсын Их Хурал, Засгийн газарт хэрэгжүүлж буй хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгасан ажил, арга хэмжээг хугацаанд нэгдсэн журамд заасан эрх бүхий байгууллага албан тушаалтанд хүргүүлнэ.

2.8.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхээр эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн чиглэлийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан тайлагнах үүрэгтэй.

Гурав. Мэдээлэл солилцох, тайлан мэдээний хөтөлөлт, хадгалалт, ашиглалт

3.1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөл нь гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн урсгалын хэвийн нөхцөл, нууцлалыг хангах ажлыг харилцан зохион байгуулна.

3.2.Шүүх эрх мэдлийн, хууль сахиулах чиг үүрэг хэрэгжүүлэх болон бусад байгууллагууд нь хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд холбогдох хууль тогтоомжийн журамд заасан мэдээллийг холбогдох байгууллагын мэдээллийн санд бүрдүүлэх үүрэг хүлээнэ.

3.3.Холбогдох хууль тогтоомжийн дагуу нууцад хамаарахаас бусад мэдээлэл байгууллагын цахим хуудсанд нээлттэй байрлуулж болно.

3.4.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөлийн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны цахим хуудсанд

дахь мэдээллийг иргэн, хуулийн этгээд нь сургалт, судалгаа, шинжилгээ, мэдээлэл зорилгоор ашиглаж болох бөгөөд тухайн мэдээллийн эх сурвалжийг заавал дурдсан байна.

3.5.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл солилцох, тайлагнах явцад төвлөрсөн мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нийгмийн бүрдүүлэлт, ашиглах үйл ажиллагаанд Архивын тухай хуулийг мөрдлөг болгоно.

Дөрөв. Мэдээлэл солилцох, тайлагнахад хориглох зүйл

4.1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл солилцох, тайлагнах явцад дор дурдсан зүйлсийг хориглоно. Үүнд:

4.1.1.Мэдээллийг хууль бусаар ашиглах, хувийн ашиг сонирхлоор хэрэглэх бусдад дамжуулах;

4.1.2.Төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулах;

4.1.3.Тайлан, мэдээ, мэдээлэл, танилцуулгыг хуурамчаар гаргаж өгөх, хугацаанд гаргаж өгөхгүй байх, хожимдуулах.

Тав. Хариуцлага

5.1.Энэхүү журмыг зөрчигчид хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.2.Энэхүү журамтай холбоотой гомдлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохицуулах Зөвлөлд гаргана.

--- оОо ---